**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ**
**БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ**
**ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 12 өдөр Дугаар А/35 Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль-ийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 13 дугаар зөвлөмжийн дагуу эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн 1 дүгээр багц диализийн аппаратыг 146,000,000 (нэг зуун дөчин зургаан сая) төгрөгөөр Их шүүдэргэнэ импорт ХХК-аар, 2 дугаар багц түнхний үений ком багажийг 97,250,000 (ерэн долоон сая хоёр зуун тавин мянган) төгрөгөөр Мөнгөн гөлтгөнө ХХК-аар тус тус гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч ажиллахыг Поликлиникийн эрхлэгч (Д.Цэцэгтуяа), гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) нарт даалгасугай.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын шаардлагад нийцээгүй 3 дугаар багц тоног төхөөрөмжийн тендерийг хүчингүй болгосугай.

4.Дээрх хүчингүй болсон багцыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ Г.ДАШЖАНЦАН

D.doc.tushaal-2024 on